



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/254

Булган

Хорио цээрийн дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а" заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын 2014 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/93 дугаар тушаалын 8.3 дахь заалт, Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 02-06-307/05 тоот, 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 06-02-315/1/26, 06-02-315/1/27 тоот, 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 06-04-323/04 тоот, 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 06-02-350/03 тоот 2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 06-02-352/14 тоот, 2018 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 03-02-302/05 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Рашаант, Гурванбулаг, Хишиг-Өндөр, Сайхан, Булган, Бугат суманд гарсан мал, амьтны гоц халдварт шүлхий өвчний шинж тэмдэг нь сүүлчийн өвчтэй мал илэрснээс хойш 28 хоног буюу сүүлчийн вакцинжуулалтыг хийснээс хойш 14 хоногийн дараа дахин илрээгүй тул хорио цээрийн дэглэмийг цуцалсугай.

2. Хорио цээрийн дэглэм цуцлагдсантай холбогдуулан Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хорогдсон мал амьтны сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийх, мал амьтны шилжилт хөдөлгөөн, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд тогтмол хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар /Ч.Амгалан/, Мэргэжлийн хяналтын газар /Б.Долгорсүрэн/, Рашаант /Б.Бат-Эрдэнэ/, Гурванбулаг /А.Эрдэнэбулган/, Хишиг-Өндөр /С.Мөнхтөр/, Сайхан /М.Ганболд/, Булган /Д.Наранбаяр/, Бугат /Х.Ууганбаяр/ сумын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Дээрх сумдын хорио цээрийн дэглэм цуцлагдсан тул Аймгийн Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/53, 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/95, 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/115, 2018 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн А/123, 2018 оны 02 дугаар 23-ны өдрийн А/101 тоот захирамжуудын үйлчлэлийг, Рашаант суманд 2018 оны 04 дүгээр сарын 17, Гурванбулаг суманд 2018 оны 04 дүгээр сарын 02, Хишиг-Өндөр суманд 2018 оны 03 дугаар сарын 30, Сайхан суманд 2018 оны 04 дүгээр сарын 18, Булган суманд 2018 оны 04 дүгээр сарын 16, Бугат суманд 2018 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөр тус тус зогссонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ

